



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/96

Арвайхээр

**Шинэ коронавирусын (COVID-19)-ын халдвараас
урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Улсын Онцгой комиссын “Зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоох тухай” 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусын (COVID-19)-ын халдвар Монгол Улсад бүртгэгдсэнтэй холбогдуулан аймаг, сум, сум хоорондох орон нутгийн зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 07:00 цагаас 03 дугаар сарын 16-ны өдрийн 07:00 цаг хүртэл зогсоосугай.


2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд архи согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

3. Хот хоорондын болон орон нутгийн зорчигч тээвэр, хувийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоосонтой холбогдуулан хот хоорондын авто замын дагуу шалган нэвтрүүлэх товчоо, аймаг сум хоорондох орон нутгийн авто замуудад хяналтын цэгүүд байгуулж ажиллуулсугай.

4. Халдварын сэжигтэй тохиолдлыг тусгаарлах орыг шат дараатай төлөвлөн бэлтгэж, голомтод ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнийг томилж, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангах, сэжигтэй тохиолдлын хавьтлуудыг тусгаарлан ажиглалтад авах байрыг эмнэлгээс тусад нь бэлтгэх, аймаг сум хоорондох орон нутгийн авто замуудад хяналтын цэгүүд байгуулах зэрэг ажлуудыг шуурхай зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг аймгийн Онцгой комисст (Uv.ontsgoi.komiss@gmail.com, uvurkhangaiemg@gmail.com) 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 08:00 цагт ирүүлэхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэ захирамжийн 1, 2, 3 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гарсан зөрчлийг тухай бүр арилгаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), Онцгой байдлын газар (дэд хурандаа Т.Мөнхдорж), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100207